

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

А.УНДРАА

**ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын төрийн өмч болох эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн сан бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Улсын Их Хурлаас Эрдэнэсийн сангийн тухай хуулийг 1994 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр анх баталж, Монгол Улсын үндэсний хөрөнгө, баялагийн дээж, давтагдашгүй үнэт зүйл болж, ирээдүйд үнэ цэнэ өсөн нэмэгдэх хуримтлал болох Эрдэнэсийн сангийн эрх зүйн байдал, өмчлөл, эзэмшлийн эрхийг хуулиар тусгайлан тогтоон баталгаажуулсан.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийг анх баталснаас хойш хорин таван жилийн хугацаанд гүйлгээний сангийн зориулалт, Эрдэнэсийн сангийн бүртгэлтэй холбоотой өөрчлөлтийг эс тооцвол зарчмын томоохон өөрчлөлт ороогүй бөгөөд энэ хугацаанд шинэчлэгдсэн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа түүх соёлын дурсгалт зүйлийг “эрдэнэс”-т тооцоогүй, үнэт чулууг хэрхэн тодорхойлох нэгдсэн зохицуулалт байхгүй, сан дахь хөрөнгийн зарцуулалт, хөдөлгөөнийг бүрэн зохицуулаагүй, эрдэнэсийн санг эрхлэхтэй холбоотой хөрөнгийн тайлан бүртгэл, хамгаалалтын талаар бүрэн тусгагдаагүй, зохицуулалт хуучирсан зэрэг асуудлууд оршсоор байна.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор тусгагдсан бөгөөд эрдэнэсийн сангийн эрхлэх үйл ажиллагааг сайжруулах талаар Үндэсний аудитын газраас зөвлөмж гарч байв.

1.2 Тухайн асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин, практикт уг асуудалтай холбоотой ямар зөрчил, дутагдал, шийдвэрлэх нийтлэг асуудал

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Эрдэнэсийн сангийн тухай хууль дахь “Эрдэнэс”-ийн тодорхойлолтод “түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл”-ийг нарийвчлан заагаагүй, олон улсад хүлээн зөвшөөрч тогтсон ангилалаас зөрүүтэй байгаагаас улбаалж эрдэнэсийн сан бүрдүүлэхэд тодорхойгүй байдал үүссэн төдийгүй, эрдэнэсийн гүйлгээ санд гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр худалдан авах цэвэршүүлсэн алтыг тусгасан нь хөрөнгийн бүртгэл,

тайлагнал, зарцуулалтын талаар олон улсад тогтсон стандарттай нийцэхгүй байна.

Мөн Монголбанкнаас эрдэнэсийн санг эрхлэх үйл ажиллагааг төрийн нэрийн өмнөөс өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх нэрлэсэн өмчлөгчийн үйл ажиллагаа болохыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуульд тусгаагүй, уг үйл ажиллагаанд хамаарах ажиллагаа нэг бүрийг заагаагүйгээс энэ төрлийн үйл ажиллагаа (үнэлүүлэх, мэдээлэх, нийтлэх) явуулах боломжгүй байх зэрэг асуудал үүсч байна.

Мөн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, зөрчлийг арилгах шаардлага байна. Тухайлбал, эрдэнэс эзэмшигч иргэн эрдэнэсээ Монголбанкинд заавал хадгалуулах үүрэг болгосон байгаа нь өмчлөгчийн эрхийг зөрчил, маргаан үүсэх эрсдэлтэй юм.

1.3 Тухайн асуудлыг хуулиар зохицуулахгүй бол гарч болох үр дагавар:

Эрдэнэсийн сангийн эрх зүйн байдлыг шинэчлэн тодорхойлохгүй тохиолдолд тус хуулийн зорилт хангагдахгүй байх, энэхүү үндэсний баялгийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар Монголбанкны үйл ажиллагаанд хууль зүйн эрсдэл үүсэх нөхцөл байдал хэвээр байна.

Дээр дурдсан асуудал, түүний шалтгаан нөхцлийг тогтоосны үндсэн дээр уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй оновчтой ганц хувилбар нь Эрдэнэсийн сангийн тухай хуулийг шинэчлэн найруулах арга зам болохыг талаар хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааны явцад тогтоож, зөвлөмж гарсан болно.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараахь байдлаар тусгана:

Хуулийн төслийн зорилго нь Эрдэнэсийн сантай холбоотой бий болсон бусад хууль тогтоомжийн болон практик өөрчлөлттэй нийцүүлэн шинэчлэх, Эрдэнэсийн санд нэмэгдсэн эрдэнэсийн тодорхойлолтуудыг шинээр хуульчлан баталгаажуулах, үүнтэй холбоотойгоор сангийн шилжилт хөдөлгөөний зарцуулалт, Монголбанкнаас эрдэнэсийн сангийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг боловсронгуй болгоход оршино.

Хуулийн төсөл "Эрдэнэс"-ийн тодорхойлолтыг өргөжүүлэх; Эрдэнэсийн гүйлгээ сангийн зориулалтыг зөвхөн үйлдвэрлэл, судалгаа, дурсгалын чиглэлээр зарцуулах; Эрдэнэсийн санд олборлосон алт авах, гадаад валютын улсын нөөц нэмэгдүүлэх үйл ажиллагааг тусгаарлах; Засгийн газраас Монголбанкинд түүх, соёлын хосгүй үнэт зүйл худалдан авах санал тавьж болох; Эрдэнэсийн сангийн эрхлэх үйл ажиллагааг өргөжүүлэх; Эрдэнэсийн сангийн бүртгэлийг олон улсын нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу Монголбанк өөрийн тайлан тэнцэлд бүртгэх; хүн, хуулийн этгээд, бусад байгууллагын эрдэнэс эзэмших, түүх, соёлын

хосгүй үнэт зүйлийн бүртгэл, мэдээллийг гаргаж өгөх эрх, үүргийг тодорхойлох; Монголбанк эрдэнэс авах, үнэт металлын сорьц тогтоох үйл ажиллагааг явуулж болох агуулгатай нийт 18 зүйлтэй, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн 50-иас дээш хувийг хамарч байгаа тул шинэчлэн найруулгын хэлбэрээр хуулийн төслийг боловсруулна.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар эрдэнэсийн эрх зүйн байдал сайжирч, эрдэнэсийн сангийн шалгуур хангасан зүйлийг Монголбанк Улсын Их Хурлаас баталсан төсвийн хүрээнд худалдан авч санг арвижуулах, эрдэнэсийн сангийн нэгдсэн бүртгэлт сайжирч, эрдэнэсийн санг эрхлэх Монголбанкны үйл ажиллагаа боловсронгуй болж, үнэт металлын сорьцтой холбоотой үсч болох санхүүгийн болон хууль зүйн хариуцлагыг төр хариуцах эрсдэл буурна. Хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд аливаа нэмэлт хөрөнгө, зардал шаардагдахгүй болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна. Уг хуулийн төсөлтэй уялдуулан Эрүүгийн хууль, Ашигт малмталын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

_____ооо_____